

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.10.27

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- ЭТТ нээлттэй хувьцаат компани болсноор хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмж, үнэлгээ өснө
- Инновейшн Инвестмент ХК-ийн цэвэр ашиг 10.8₮ тэрбумд хүрлээ.
- MSE:CUMN хөрөнгө оруулагчдын авсан дундаж ханш 183.2₮ байна.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.6%	1.93%	25.47%
MSE A	0.12%	7.58%	20.27%
MSE B	-1.56%	0.2%	34.89%

2025/10/20 – 2025/10/24

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
MGLA	996,749,171.00
QPAY	937,803,752.22
INV	759,153,195.00
KHAN	416,190,747.00
ERDN	259,549,240.00

2025/10/20 – 2025/10/24

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
OLL	22.80	19.94%
TVL	25,780.00	14.99%
AOI	2,181.00	14.97%
ADL	450.00	12.50%
BDS	2,875.00	12.26%

2025/10/20 – 2025/10/24

2025 он 10-р сарын 27

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,988

ТОП-20 индекс

48,824

MSE A

18,957

MSE B

14,341



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,874.52

2025-09 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,591.13

2025-10-26



Эдийн засгийн мэдээлэл

ЭТТ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОХ НЬ ХЗЗ-Д ЯАЖ НӨЛӨӨЛӨХ ВЭ?

Монголын хамгийн том стратегийн орд “Эрдэнэс Тавантолгой”-г нээлттэй хувьцаат компани болгох асуудал олон жил яригдсан ч бодит алхам ховор байв. Харин 2025 оны 9-р сарын 18-нд төрийн болон мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулагдсанаар энэ асуудал дахин анхаарлын төвд орсон билээ.

Өнөөдрийн байдлаар тус компанийн хувьцаа 3.4 сая иргэн, аж ахуйн нэгжид ногдож байгаа ч арилжаалах боломж хязгаартай хэвээр. Хэрэв компанийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалбал иргэд өмчөө эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгийн зах зээл тэлж, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэх суурь тавигдана.

Өнгөрсөн сард болсон хэлэлцүүлгийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ахлагч У.Бямбасүрэн нээж, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд бүх талын оролцоо чухлыг онцлов. УИХ, Сангийн яам, СЗХ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг 14 байгууллага оролцсон нь уг асуудлыг хурдан хугацаанд шийдэх боломжтойг харуулсан билээ.

Тэгвэл өнгөрсөн долоо хоногт Ерөнхий сайд Г.Занданшатар УИХ-ын чуулганы үеэр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг ирэх оны цагаан сараас өмнө нээлттэй хувьцаат компани болгоно гэж мэдэгдлээ. Тэрээр энэ алхам нь нүүрсний хулгайг таслан зогсоож, компанийн засаглалыг ил тод болгох мөн зорилготой гэв. Өнөөдрийн байдлаар монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 12.98 их наяд төгрөг байгаа ба хэрэв ЭТТ нээлттэй хувьцаат компани болбол энэ үнэлгээ 20 орчим их наяд төгрөг болох боломжтой.

MSE: QPAY ИННОВЕЙШН ИНВЕСТМЕЭНТ ХК-ИЙН ЦЭВЭР АШИГ 10.8₮ ТЭРБУМД ХҮРЛЭЭ

2025 оны 3-р улирлын байдлаар тус компанийн цэвэр ашиг 10.8 тэрбум төгрөгт хүрч 2024 оны цэвэр ашиг болох 10.02 тэрбум төгрөгийг давуулан биелүүллээ. Магадгүй энэ оны эцсийн байдлаар цэвэр ашиг нь 14 орчим тэрбум төгрөгт хүрэх магадлалтай. Мөн нийт өөрийн хөрөнгө нь 26.3 тэрбум төгрөгт хүрч 2024 оны жилийн эцсээс хойш 57.7 хувиар нэмэгдээд байна.

Мөн өнгөрсөн жил 10 тэрбум цэвэр ашгийнхаа 7.4 тэрбумыг ногдол ашиг хэлбэрээр тараасан юм. Хэрвээ 2025 оны цэвэр ашиг 14 орчим тэрбум төгрөг байна гэж үзвэл ногдол ашгийн хэмжээ 10 тэрбум төгрөг хүртэл нэмэгдэх магадлал өндөр билээ. Иймээс хувьцааны ханшийн өсөлтөөс гадна ногдол ашгийн өгөөжөөс ч давхар ашиг хүртэх боломж QPAY-н хувьд байна.

Яг одоо QPAY хувьцааны ханш 207 төгрөгөн дээр арилжаалагдаж байгаа бөгөөд P/E буюу үнэ ашгийн харьцаа 3.13 байгаа нь 3 жилийн цэвэр ашиг өнөөдрийн зах зээлийн үнэлгээтэйгээ тэнцэж байна.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 БА ПРЕИУМ НЭКСУС ХК (MSE:CUMN) ҮНЭЛГЭЭ

График 1. ТОП-20 ба CUMN үнэлгээний харьцуулалт






График 2. ТОП-20 ба CUMN үнэлгээнд үндэслэсэн ханш



CUMN хувьцааны үнэлгээний үзүүлэлтийг ТОП-20 индексийн үнэлгээтэй харьцуулж үзэн ханшийн таамаглалыг тооцож үзвэл хамгийн багадаа 245₮, хамгийн ихдээ 357₮-т хүрэх боломжтой гэж таамаглаж байна. Мөн P/E харьцаа дунджаас доогуур байна.


ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ДУНДАЖ ХАНШ 183.2₮

График 3. CUMN хувьцааны ханш



ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

